



Г ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Л.ХАЛТАР ТАНАА

МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2022.03.28 № 01/4218  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


Г Зөвлөмж хүргүүлэх тухай Г

Авлигатай тэмцэх газраас авто тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох үйл ажиллагаанд авлигын гэмт хэрэг, зөрчил гарч буй асуудлаар хүргүүлсэн зөвлөмжийн хэрэгжилттэй газар дээр нь танилцан, нөхцөл байдлыг судлан үзэж, гэмт хэрэг, зөрчил дахин гарах эрсдэлээс сэргийлэх зорилгоор холбогдох зөвлөмжийг хүргүүлж байна.

Зөвлөмжийн мөрөөр холбогдох арга хэмжээг авч, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.6-д заасны дагуу биелэлт, үр дүнгийн талаар 2022 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дотор хариу ирүүлнэ үү.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА,  
ТЭРГҮҮН КОМИССАР



З.ДАШДАВАА

142203006779

Авлигатай тэмцэх газрын даргын  
2022 оны 03 дугаар сарын 28-ны  
өдрийн 01 дугаар албан бичгийн  
хавсралт

### АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ЗӨВЛӨМЖ

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/222 дугаар тушаалаар “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-ыг шинэчлэн баталж, хууль тогтоомж зөрчсөн зарим зүйл, заалтыг хүчингүй болгож, зарим асуудлыг шинээр тусган, салбарын албан хаагчдыг авлигын гэмт хэрэг, зөрчил үйлдэх эрсдэлээс сэргийлэх нөхцөлийг бүрдүүлсэн болно. Энэхүү журамд Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/136 дугаар тушаалаар 6 зүйл, заалтыг нэмж тусгажээ. Үүний дотор дээр дурдсан журмаас хүчингүй болгосон асуудлыг буюу “Импортоор оруулж ирсэн шинэ болон ашиглагдаж байсан автотээврийн хэрэгслийн үйлдвэрлэгчийн, эсхүл экспортын дагалдах баримт бичиг, автотээврийн хэрэгслийг тухайн улсаас экспортлохын өмнөх үеийн техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт”-ийг хийлгэж байх “3.3.4” дэх заалтыг дахин журамд нэмж оруулсан байна. Энэхүү асуудлыг Монгол Улсын дотоодын хууль тогтоомж, журмаар зохицуулахад хүндрэлтэй төдийгүй журмын хэрэгжилтийн явцад гадаад улсаас авто машин импортоор оруулж ирдэг иргэн, аж ахуйн нэгжид хүнд суртал, чирэгдэл учрах, иргэдэд нэмэлт төлбөрийн дарамт болох нөхцөлийг бүрдүүлж байна.

Иймд “Автотээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам”-д тусгасан хуулиас давсан зохицуулалтыг хүчингүй болгох шаардлагатай.

2. Автотээврийн үндэсний төвөөс гаргуулсан мэдээллээс үзэхэд автотээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдаа зохион байгуулах талаар 2021 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс хойш 16 удаа зар байршуулж, 300 удаагийн дуудлага худалдаа зохион байгуулж, нийт 2165 дугаар борлуулж, 4,020,400,000 төгрөгийн орлого олжээ. Дуудлага худалдаанд оролцогчдыг судлан үзэхэд зарим иргэд олон давтамжтайгаар оролцсон байна. Тухайлбал, нэг иргэн хамгийн олон буюу 99 дугаар



дуудлага худалдаагаар авсан бөгөөд өрсөлдөгч гарч ирсэн тохиолдолд дуудлага худалдааны үнийг санаатайгаар хэт өсгөн дугаарыг худалдан авч, дараа нь Дуудлага худалдаа зохион байгуулах удирдамжийн 4 дүгээр зүйлийн 4.4-т "энэхүү удирдамжийн 3.8-д заасан хугацаанд буюу 24 цагийн дотор АТҮТ-ийн дансанд улсын бүртгэлийн дугаарын үнэ төлөгдөөгүй тохиолдолд тухайн улсын бүртгэлийн дугаарыг дахин дуудлага худалдаанд оруулах бөгөөд дэнчинг /50,000 төгрөг/ буцаан олгохгүй" гэсэн заалтын дагуу тухайн дугаарыг хүчингүй болгох, тухайн дугаарыг дахин дуудлага худалдаанд оруулах нөхцөл байдалд хүргэх, нөгөө талаас дэнчингийн хэмжээ хэт бага байгаа нь нь автотээврийн хэрэгслийн улсын дугаарын ченж гэх хүмүүсийг бий болгож, иргэдийн шударга өрсөлдөх боломжийг хязгаарладаг байж болзошгүй юм. Тухайлбал, Дуудлага худалдаанд оролцсон 19400 оролцогч төлсөн дэнчингээ буцаан авах хүсэлт гаргаж 970,000.000 төгрөгийг АТҮТ буцаан олгосон байна.

Иймд Тээврийн хэрэгслийн улсын дугаарын дуудлага худалдаанд иргэн бүр оролцох боломжийг бүрдүүлэх зорилгоор дуудлага худалдааг тогтмол зохион байгуулах, дэнчингийн хэмжээг нэмэгдүүлэх, үр дүнг тухай бүр иргэдэд ойлгомжтой байдлаар мэдээлж ажиллахыг зөвлөж байна.